

ХЭЛЦ НЭРЛЭЛТ ҮҮСЭХ ӨВӨРМӨЦ ОНЦЛОГ

Л. Ганчимэг *

Хэллэг, хэлцэжсэн холбоо үг, өвөрмөц хэллэг, хэвшмэл хэллэг зэрэг тогтвортой холбоо үг үүсэх арга, түүний бүтэц-утгазүйн хэв шинжийн талаар хийсэн судалгаа олон байдаг.

Хэлц үүсэх онцлог нь үг бүтэх ёс зэрэг хэлэнд үүсдэг аливаа шинэ үүсвэр бүтэцтэй ямар холбоо хамааралтай байж болох тухай асуудал судлаачдын анхаарлыг татаж байна. Ялангуяа “дотоод хэлбэр”-ийн мөн чанарыг шинжлэн тайлбарлахад энэ хамаарлын учир холбогдлыг таньж мэдэх шаардлагатай болдог. Өөрөөр хэлбэл, хэлц нэгж шинээр бүтэх онцлогийг судлан тайлбарлахдаа:

1. Хэлний ямар материал хэрэглэгдэхүүн юмуу, ямар махбодод суурилдаг болох,
2. Тухайн шинэ бүтэц-нэгж үүсэх ямар шалтгаан учир байсан,
3. Шинж үүсгэвэр (derivation) бий болох үйл явц нь ямар эрэмбэ дараалалтай хэрэгжих зэрэг асуудлыг юуны өмнө нарийвчлан тодорхойлох ёстой¹ гэж үздэг.

Гэвч хэлц нэгж үүсэх арга оньсыг загварчилж болох уу, үгүй юу гэдэг асуудал нэг мөр болж хараахан шийдэгдээгүй ажээ. Өөрөөр хэлбэл, хэлц нэгж, ялангуяа өвөрмөц хэллэг үүсч байгаа байдлыг ажиглавал, уг үзэгдэл нь утга хэлбэрийн аль ч талаараа тодорхой хэв загварт орох боломжгүй мэтээр зарим судлаач тэмдэглэсэн байдаг.

Ингэхлээр, Хэлц нэгж нь:

1. Хамгийн их бүтэцтэй дагавар ч юм уу, эсвэл нэр, үйлийн нөхцөл шиг маш олон үг хамардаг биш, тодорхой тоотой, хэвшиж тогтсон бүтэц, хэв маягтай байдаг. Жишээлбэл: гар нийлэх, сэтгэл нийлэх, ам нийлэх гэсэн өвөрмөц хэллэг бий. Хэрэв үгийн сангийн утгын эсрэг үгээр бодвол “нийлэх”-ийн эсрэг нь “салах” байж болно. Үүнээс үүдээд гар нийлэх ~ гар салах, сэтгэл нийлэх ~ сэтгэл салах, ам нийлэх ~ ам салах гэсэн эсрэг утгатай хэллэг үүсэхгүй. Түүнчилэн толгойгоо ганзгалах, гуяа ганзгалах гэх хэрнээ, “толгой” гэдэг үгтэй утгаараа эсрэгцсэн “хөл” гэдэг үгтэй холбогдсон “хөлөө ганзгалах” гэдэг өвөрмөц хэллэг үүсээгүй байна. Мөн хөлгүй баян, хөлтэй баян гэх хэрнээ толгойгүй баян, толгойтой баян гэх хэллэг үүсч хэрэглэгдэхгүй байна. Харин “толгойтой баян” гэдгийг мал хөрөнгө, мөнгө хөрөнгөөр баян боловч, түүнийгээ яаж ашиглаж хэрэглэх, улам арвижуулах ухаан хомс шинжийн тодорхойлол болгон “шинээр” зохион хэрэглэж болох юм. Тэгвэл “толгой” нь ухааны төлөөлөл (синегдоха) болдогтой холбоотой үүссэн хэллэг болох юм.

* МУИС-ийн МХСС-ийн Хэл шинжлэлийн тэнхим

¹⁾ Гвоздарев Ю.А. *Основы русского фразеологического образования*, Ростов на Дону, 1977., стр 43-44

2. Үг бүтэх ёсонд хоньчин, ямаачин гэдгийн адилслаар зөгийчин, галуучин гэж үүсч болдог шиг ийм тийм хэлц нэгж үүснэ гэж урьдчилан таамаглах боломжгүй байдаг. Өөрөөр хэлбэл, "цагаан зам" гэвэл саадгүй гэсэн утгатай гэдгийн адилслаар бодож, "хар" гэдэг эсрэгцсэн утгатай өнгөний нэрээс дээрх загвараар "хар зам" гэж хэллэг үүсгэн хэлэлцвэл энэ нь "саадтай (муу) зам" гэсэн утгатай хэллэг үүснэ гэж урьдчилан хэлэх боломжгүй юм. Мөн "малаа хужирлах" гэдэг бүтэц утгазүйн загварыг хийсвэрлэн "нүдээ хужирлах" гэдэг хэллэг үүссэн шиг "шүдээ хужирлах" гэдэг хэллэг үүсэх боломжгүй.

Энэ мэтээр "толгойгоо даах" гэдэг хэллэгийн аналогior "хөлөө даах" гэх ч юм уу, эсвэл "толгойгоо өргөх" гэх зэрэг хэллэг үүсэх боломжтой гэж урьдчилан таамаглах боломжгүй. Үүнээс үүдээд,

3. Харилцааны тодорхой зорилгоор, тодорхой орчин нөхцөлд чухам ямар хэллэг хэрэглэвэл зохистой вэ? гэдгийг бодолцож, тэр болгонд нийцүүлэн хэлц нэгжийг сонгож хэрэглэдэг. Ийм учраас нас барсан хүний насны хэмжээ, амьд сэрүүндээ эрхэлж байсан ажил үйлийн онцлог буюу нийгэмшлийн байдал, хүндэтгэл, цээр, ёр зэргээс үүдэж "үхэх" гэдэг утга санааг илэрхийлэх: бурхан болох, жанч халах, тэнгэрт халих, өөд болох, хадан гэртээ одох, бүтээгүй гэх мэт олон арван хэллэг үүссэнээс харилцааны тодорхой орчин нөхцөлд аль зохимжтойг нь сонгон хэрэглэдэг. Үүний нэгэн адилаар "Хирээ мэдэхгүй ихэд санаархах" гэсэн утга санааг илэрхийлэх:

- Саваагүй нохой саранд хуцах
- Шал чомоггүй туг ширээ
- Бардам ам, шалдан гуя
- Гоё ам, гурил хошуу
- Санаа нь тэнгэрт, салтаа нь цасанд
- Тэмээнд хүрэхгүй гараа тэнгэрт сарвалзах
- Оготны дуу тэнгэрт хүрэхгүй
- Хирээ мэдэхгүй хэрээ луугийн маханд дурлах гэх мэт хэллэгүүд хэдийгээр ойролцоо утгатай боловч алиныг нь ч гэсэн аав, ээж, ах, эгч, багш сургагч зэрэг эрхэм хүндэт хүнийхээ хэрэг явдал, үйл ажилд дургүйцсэний илэрхийлэл болгон огтхон ч хэрэглэдэггүй онцлогтой байна.

Дээр өгүүлснийг хураангуйлан хэлбэл, хэлц нэгж нь:

1. Тогтсон загвараас чөлөөтэй үүсэх боломжгүй.
2. Ийм тийм хэллэг үүснэ гэж урьдаас таамаглан хэлэлцэх бололцоогүй
3. Хэлэнд буй олон мянган хэллэг, тэр ч байтугай, ойролцоо утгатай хэдэн зүйл хэллэгээс харилцааны тодорхой орчин нөхцөлд зөвхөн аль нэг тодорхой хэллэгийг л сонгон хэрэглэхээс өөр аргагүй гэсэн онцлогтой байна.

Ийм учраас хэлц нэгжийг үүсгэх бүтэц- утгазүйн хэвшинжид нь тулгуурлан загварчлах боломжгүй юм.

Ийнхүү бүтэц- утгазүйн шинжийг ашиглах нь өвөрмөц хэллэг үүсэх оньс, онцлогийн зүй тогтлыг нээж гаргахад ихээхэн үр дүнтэй арга болдог.

Тэгвэл хэлц нэгжийг загварчилж болох нэг арга нь тэмдэглэхүүн буюу денотат шинжид нь тулгуурлах ёстой гэж үзэж болно.

Тэмдэглэхүүн (денотат) буюу Нэрлэлзүйн (ономасиологи) үүднээс хийх загварчлалын үндсэн хандлага ч гэсэн шууд бус нэрлэлт үүсэх утгазүйн эх сурвалж, түүний хийсвэрлэн сэтгэх аргад тулгуурлахаас өөр аргагүй юм.

Гэхдээ нэрлэлзүйн (ономасиологи) үүднээс хийж буй шинжилгээний гол онцлог нь илэрхийлэхийг зорьсон утга санааг үүтгэл болгож, түүнийг илэрхийлж буй хэлбэр лүү нь хандуулан уялдуулах явдал ажээ.

Өөрөөр хэлбэл, “Ачийг бачаар (хариулах)” гэсэн санааг:

- Өөх өгсөнтэйгөө өглөө заргалдах
- Нүүр өгөхөд бөгс өгөх
- Ор гэхэд шагайж, ооч гэхээр долоох
- Ишиг эврээ ургахлаар эхийнхээ дэлэнг мөргөх
- Тэжээсэн бяруу тэрэг эвдэх
- Хүн тэжээвэл толгой цусдах, мал тэжээвэл ам тосдох
- Баасы нь идээд эзний нь зуух
- Сүүн сэтгэлийг ээдүүлж, тосон санааг царцаах гэх мэт олон зүйл хэллэгээр илэрхийлэх боломжтой байгааг загварчлал, ангиллын үндэс болгон үзэх ёстой болно.

Нэрлэлзүйн энэ чиг хандлагыг үндэс болгон монгол хэлний хэлц нэгжийг ангилах боломжоос зарим жишээг үлгэрлэн үзүүлвэл:

“Тэс зөрүү, шал эсрэг” хэмээх санааг:

- Нугасы нь олохгүй, нууры нь олох
- Нүдий нь олохгүй, нүүрий нь олох
- Шаваа онохгүй, тэнгэр онох
- Шилээ загатнахад түрийгээ маажих
- Зээр гэхээр бөөр гэх, зэс гэхээр гууль гэх
- Тэмээ гэхэд ямаа гэх
- Хүнээс этгээд, тэмээнээс гэдгэр
- Байнд ч үгүй, банзанд ч үгүй гэх мэт.

“Ханийн сэтгэлгүй хуурамч” хэмээх санааг:

- Бие нь хөрөөгүй байхад бишдийг бодох
- Өнгөрсний өрхийг бүтээнгээ өрөөлийн өврийг хүсэх
- Нүд анимагц нөгөөхөө даллах*

Тэгвэл “өөрийн мэдэлгүй” гэх санааг:

- Гүзээнд наалдсан дэлүү
- Дөрлүүлсэн бух
- Сүүдэр
- Салхины аясаар
- Зүү хаашаа бол утас тийшээ
- Эрэг хаашаа бол ус тийшээ
- Далайсан газар далд орж, далласан газар ил гарах
- Тогоруу шиг тонголзож, галуу шиг ганганах
- Гэрийн боол, гэзэгний уяа болох
- Гарын боол, ганзаганы уяа болох
- Боолын боол, босгоны шороо болох
- Хүний ам/гар харах
- Хүний/ айлын тогоо өнгийх

* эдгээр хэллэгийг Чой.Лувсанжав. Орос-монгол өвөрмөц хэллэгийн толь Уб. 1970., хуу 20, ишилсэн болно. “*Башмаков она еще не износила*” хэмээх орос хэллэгийн утга санааны дүйлгэ болгон жишээлсэн байна.

- Хүний/ айлын шавхруу горьдох гэх мэт хэллэгээр илэрхийлж байна.

“Хуурах, мэхлэх” гэсэн санааг

- Маллах

- Толгойг нь эргүүлэх

- Нүдий нь хуурах

- Молиго үмхүүлэх

- Араар нь тавих

- Нүглийн нүдийг гурилаар хуурах

- Нэр бөглөх

- Алба өнгөрөөх

- Ам хаах

- Нэр хаахчаан аядах

- Чулуу хөөлгөх

- Хөвөнд боосон чулуугаар цохих гэх мэт

“Бүтэшгүй, биелэшгүй” гэх санааг:

- Харганы унгасаар эсгий хийх

- Эр үхрийн сүүгээр элгэн тараг бүрэх

- Үнсээр чөдөр зангидах

- Элсээр гэр барих

- Нар баруун хойноос гарах

- Шүүдрээр ус хийх

- Шүүдрийн усаар цай чанах

- Төрөл арилжих

- Хойт насандаа (болох)

- Солонго хөөх

- Чоно махнаас гарах

- Тулгаа үдээрээр үдэх

- Хөхөөг хүйдсээр нь цохих

- Зангууны үлгэр болох

- Хар усан дээр өрөм тогтоох

- Үхэр хэдгэнийг дээсээр бугуйлдах

- Цоорхой/ ёроолгүй хувингаар ус зөөх

- Алганыхаа хонгорхойг хазах

- Тэмээний сүүл газар шүргэж, тэхийн эвэр тэнгэрт тулах

- Нарыг нум сумаар харвах

- Үхсэн эмгэнээс унгас эрэх*

Эдгээр хэллэгийн үүсгэвэр үндсийг ажиглавал: “Эр үхрийн сүүгээр элгэн тараг бүрэх”, “Үнсээр чөдөр зангидах” гэдэг нь монгол ардын “Цэцэн бэр”-ийн үлгэрийн санаанаас, “Хөхөөг хүйдсээр цохих”, “Нар сарыг нум сумаар харвах”, “Тэмээний сүүл газар шүргэж, тэхийн эвэр тэнгэрт тулах” зэрэг нь монгол ардын өөр нэг домог үлгэрээс үүсгэвэртэй, бусад зарим нь ард олны дунд ам дамжин хэрэглэгдсэн хэллэг байна.

* эдгээр хэллэгийг Чой.Лувсанжав. Орос-монгол өвөрмөц хэллэгийн толь УБ. 1970., хуу 106. ишилсэн болно. Уг хэллэгийг орос хэлний “вилами по (на) воде писать” (сүүлээрээ усан дээр бичих/зурах) гэдэг хэллэгтэй утга дүйлгэж жагсаасан байна.

Хэлц нэгжийг ийнхүү концепт буюу багцалмал мэдлэгийн хүрээгээр нь загварчлан ангилах нэг арга байна гэж үзэж болно.

Концепт буюу багцалмал мэдлэг гэдгийг “ухагдахууны оллиг” хэмээн ойлгож байна. Өөрөөр хэлбэл, нэг концепт-д хэд хэдэн ухагдахуун багтана гэсэн үг юм. Ийм учраас тухайн концепт-д багтаж, багцалмал мэдлэгийн нэг орон болсон хэллэгүүд нь утга ойролцоо боловч, найруулгазүйн өнгө аясаараа бие биенээсээ ялгарах онцлогтой байна.

Хэлцээр нэрлэлт үүсгэж буй юм үзэгдэл, үйл явдал, шинж чанар нь маш олон талтай байдаг. Энэ олон талт шинж нь чухамдаа түүнийг сонирхож сонжсон, таньж мэдсэн, ухаарч ойлгосон хүний сэтгэц, сэтгэхүй, танин мэдэхүйн үйл ажиллагааны олон өнцөгт, олон талт үйл ажиллагааны агуулга болно. Энэ нь сэтгэцийн авалцуулан холбох (ассоциаци) үйл ажиллагаа юм.

Авалцуулан холбох үйл ажиллагааны үр дүн нь ухагдахууныг хэлцээр илэрхийлэх үйл явцаар хэрэгжинэ.

Нэрлэгдэж буй объектийн тухай мэдээлэл үүсгэх авалцуурын агуулга, хүрээ маш олон янз байна. Зарим нь бодгаль, хувь хүний шинжтэй, зарим нь тухайн угсаатан ястан, хамт олон, үндэстний сэтгэлгээний нийтлэг хэв маягийн илэрхийлэл байдаг. Бодгаль, хувь хүний шинжтэй үүссэн авалцуур, түүний илэрхийлэл болсон хэллэгийг зохиогчийн хэллэг хэмээн үзэх нь ч бий.

Эдгээр олон талт, олон шинжит, олон хэв маяг бүхий хэллэгийн аль нь ч гэсэн бодит байдлын юм үзэгдэл, үйл явдал, нөхцөл байдал, шинж чанарыг онцлон нэрлэх төдийгүй, түүнийг сонсох, эсвэл унших хүний сэтгэлийг хөндөх, сэтгэцэд нь нөлөөлөх, сэтгэлийг нь хөдөлгөх, уг үзэгдэл юмын талаар үнэлэмж үүсгэх, өөрийн үнэлэмжээ мэдрүүлж, тэр талаар нийцтэй, эсвэл нийцгүйн хариуг сонсогч / уншигчаас авах зорилгыг заавал давхар агуулж байдгаараа хэлц нэгж нь өвөрмөц нэрлэлт болно.

Ийм үүднээс хэлц нэгжийн утгыг шинжлэхэд түүний “дотоод хэлбэр”-ийг зөв таньж мэдэх явдал хамгийн чухал. “Дотоод хэлбэр”-ийг зөв таньж мэдэх үйл ажиллагаа нь дүрслэн бодох, уг юм үзэгдэл, үйл байдал, шинж чанарын тухай дүр дүрслэлийг санаандаа ургуулан бодож, цогцлоон үүсгэх сэтгэц, сэтгэхүйн үйл ажиллагаанаас ангид авч үзэх аргагүй юм. Өөрөөр хэлбэл “дотоод хэлбэр” бол хэлц нэгжийн утгазүйн бүтцийг тодорхойлох гол бүрэлдүүлбэр юм. Иймээс “дотоод хэлбэр” нь өвөрмөц хэллэгийн дүрслиг шинж, мөн уран яруу илэрхийлэх шинжтэй нь маш нягт уялдаатай юм. Мөн тухайн өвөрмөц хэллэг нь дүрслиг сэтгэлгээний илэрхийлэл болж, бас ямар нэг хэрэг явдал, үйл хэрэг, шинж чанар, нөхцөл байдлыг уран яруу илэрхийлэхийг хэлц нэгжийн “дотоод хэлбэр” хэмээх шинжээс ангид авч үзэх аргагүй ажээ.

Ингэхлээр хэлц нэгжийн утга бол бодит ертөнцийн тухай үнэн тусгал (рационал), сэтгэл хөдлөлийн тусгал хоёрын давхцал байдгаараа өвөрмөц нэрлэлт болно.

Уг юм үзэгдэл, үйл байдал, шинж чанарыг таньж мэдэхэд чиглэсэн олон янзын авалцуур (ассоциаци)-ын зөвхөн нэг нь л хэлц нэрлэлт үүсэх/үүсгэх шалтгаал (мотив) болно. Жишээлбэл: “Хэрэг явдалд азгүйтэх, улмаар мухардах” хэмээх санааг

- Элс үмхэж, эрэг мөргөх
- Шороо үмхэх
- Газар үмхэх
- Хар хоншоороороо газар хатгах
- Үнсэнд хаясан шалз (болох)
- Заяа нь хаях

- Эзэн (эз) нь хаях
- Тэнгэр нь хаях
- Од нь үхэх
- Туг нь үхэх
- Сүр сүлд нь үхэх
- Хийморий нь ямаа хивэх
- Хийморий нь сүүдэр дайрах
- Хийморь нь үхэх
- Заяаных нь нүдэнд зүү шааж, залааных нь үзүүрт идээ буглах
- Өөдөө нарны бараа харахаа болих
- Уутны ам нь уруугаа харах
- Үйлс нь бараантах
- Амны хишиг нь ар дээрээ гарах
- Хувь нь дутах
- Амны хишиг дутах гэх мэт маш олон хэллэгээр илэрхийлсэн байдаг.

Дээрх хэллэгийн утгыг дүрслэн сэтгэж, ургуулан бодох аргаар ажиглавал, явж байгаа хүн амьтан тэнцвэрээ алдаж унавал “газар үмхэх, шороо үмхэх, элс үмхэж эрэг мөргөх, хар хоншоороороо газар хатгах” нь ойлгомжтой болно. Энэ бол уг илэрхийллийн шууд утга юм. Үүнийг тухайн хэллэгийн “дотоод хэлбэр”-ийн үндэс ч гэж үзэж болно. Энэ шууд утга буюу “дотоод хэлбэр”-т суурилж, зорьсон хэрэг үйл бүтэмжгүй болох, азгүйтэж мухардах” гэсэн хийсвэр утга үүснэ.

Нөгөөтээгүүр уг санааг эз(эзэн), заяа, сүр сүлд, хишиг хувь, хийморь, од, туг” гэх мэт хийсвэр нэрлэлт, түүнтэй холбоотой зан үйл, ухаарал, мэдлэгтэй холбож, түүнд тулгуурласан дам хийсвэрлэсэн нэрлэлт үүссэн байна.

Түүнчилэн аливаа уут сав бол ямар нэг юмыг дотор нь агуулах зориулалттай зүйл болно. Юмтай уут савны амсрыг доош нь (уруу нь) харуулбал доторх юм нь унаж асгарна. Сав хоосорно. Хүн олз омогтой байх гэдэг бол аз хийморьтой байхын бэлгэдэл болно. Ингэхлээр аз хийморьгүй болохыг “уутны ам нь уруугаа харах” хэмээх хэллэгээр ийнхүү хийсвэрлэн илэрхийлсэн байна. Тэгвэл эхний утга нь шууд утга, бас зүйрлэсэн утга буюу хэллэгийн утга үүсэх “дотоод хэлбэр” нь болно.

Шууд утгад тулгуурлаж, түүнийг “дотоод хэлбэр”-ээр нь дамжуулан хийсвэрлэж, хэллэгийн утгыг үүсгэдэг учраас аливаа өвөрмөц хэллэгийн утга бол хэлний илэрхийллээр хийсвэрлэн сэтгэх үйл ажиллагааны хамгийн дээд эрэмбийн хийсвэрлэл болж байна.


Дээр жишээлсэн хэллэгийн дотор “хийморий нь ямаа (тугал) хивэх” гэдэг нэг хэллэг бий. Үүний нарийн утгыг бүрэн дүүрэн, зөв тайлахын тулд нэгдүгээрт, “хийморь” гэдэг ойлголт, түүнтэй холбоотой цогц мэдлэг шаардлагатай болно. Үүний зэрэгцээгээр, хоёрдугаарт, олом жирэм, ганзага, жолоо, цулбуур, гөлөм зэрэг арьс ширээр хийсэн тоног хэрэгслийг ямаа, үхэр зажилж хивчихсэн байдаг бас нэг хэв шинжит үзэгдлийн тухай учир утга, мэдлэг ухаарал зайлшгүй шаардлагатай болно. Гуравдугаарт, “ганзага”-тай холбоотой, түүнийг юугаар хийдэг, юунд бэхэлдэг, ямар зориулалттай эд болох, түүнтэй холбоотой монголчуудын уламжлалт элдэв зан үйл, үйл ажиллагааны бас нэг цогц мэдлэг ухааныг ойлгож мэдэх учиртай болно.

Үүнээс үндэслээд дөрөвдүгээрт, монголчуудын уламжлалт аж төрөх ёс, арга ухаан, ёс заншил, ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таньсан ухаан, арга ажиллагааны үүднээс

“ганзага”, “хийморь” хоёрын хооронд авалцуур (ассоциаци)-аар үүсэх бас нэг шинэ мэдлэг ухаарал зайлшгүй хэрэг болно.

Ингээд эдгээрийн авалцуураас хийсвэрлэн “азгүйтэх, хэрэг үйл бүтэмжгүй болох, мухардах” гэсэн санааг илэрхийлсэн хийсвэрлэлийн сүүлчийн (тагдахь) шатанд “хийморий нь ямаа хивэх” гэдэг хэллэгийн зорьсон утга хэлбэржиж хэрэглэгдэх зүй тогтолтой байна.

Хэлц нэгжээр нэрлэх сэтгэцийн оньсыг Т.Г.Никитина² дараах байдлаар загварчлан томъёолсон нь бидний өмнө жишээлсэн хэллэгтэй агуулгаараа тохирч байна. Үүнд:



гэсэн шатлал бүхий оньс байхыг тодорхойлсон байна.

Эндээс товчхон дүгнэвээс, хэлц гэдэг бол хамтран нэгэн санааг илэрхийлж дэвшсэн хэд хэдэн үгийн нэгдэл юм. Хэлц үг, хэллэгэнд холбогдож байгаа үгийн өөр хоорондын нэгдэл нь салшгүй хэвшин тэр хэлэндээ үргэлж бэлэн материал болон утга хэрэглээний хувьд нэгэн цогц болдог нь түүний гол чухал шинж мөн болно.

SUMMARY

This is article is about how phrases are made up of significant features. Phrases express units of words and it are related to concepts which are related to worldview. Therefore, the words created by phrases are the ready materials of language.

²⁾ Никитина Т.Г. Специфика фразеологической номинации // Проблемы фразеологической номинации. Санкт-Петербург. 1996., стр 85